

2024 ОНЫ ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ

Эрчим хүчний сайдын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/178 дугаар тушаалаар “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин” батлагдсан бөгөөд төлөвлөгөөт үзүүлэлтийн биелэлтийг бүрэн хангаж ажилласан.

Д/д	Үзүүлэлтүүд		х.н	2023 он гүйц	Тайлант он		Төлөв-өөс	
					Төл	Гүйц	Хувь	Дүн
1	Боловсруулсан ЦЭХ		сая.квтц	152.4	165.6	175.2	106%	9.6
2	ДХЦЭХ	Биетээр	сая.квтц	19.0	20.4	19.8	97%	(0.6)
		Хувиар	хувь	12.4%	12.3%	11.3%	92%	(0.0)
3	Эрчим хүч түгээлт	Цахилгаан	сая.квтц	133.4	145.2	155.36	107%	10.2
		Дулаан	мян.Гкал	264.0	251.6	260.8	104%	9.3
4	Нийт орлого		сая.төг	34,499.5	37,383.6	39,096.5	105%	1,712.9
	Үүнээс: Цэвэр борлуулалт		сая.төг	34,138.5	37,076.3	37,804.0	102%	727.7
5	Нийт зардал		сая.төг	34,488.8	39,568.8	38,975.6	99%	(593.3)
	Үүнээс: Үйл ажиллагааны бус зардал		сая.төг	170.5	194.0	417.9	215%	223.9
6	Ашиг / алдагдал /		сая.төг	10.7	-2,185.2	121.0	-18.07	2,306.2
	Цэвэр ашиг / алдагдал /		сая.төг	7.4	-2,185.2	106.1	-20.59	2,291.3
7	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал		төг	1.0	1.1	1.0	94%	(0.1)
8	Авлага		сая.төг	1,280.3	1,365.0	1,651.9	121%	286.9
9	Өглөг		сая.төг	1,839.1	1,263.7	1,276.4	101%	12.7
	Үүнээс: Богино хугацаат өглөг		сая.төг	1,483.5	950.0	962.6	101%	12.6
10	ХО, ИЗ, ТЗБАХ-ний зардал		сая.төг	2,609.7	3,313.5	2,215.2	67%	(1,098.3)
11	Жишмэл түлшний зарцуулалт ЦЭХ		гр/квтц	596.2	615.3	549.4	89%	(65.9)
	ДЭХ		кг/Гкал	197.3	200.6	193.5	96%	(7.1)
12	Нийт ажиллагсдын тоо		тоо	280	311	290	93%	(21.0)
13	Нийт цалингийн сан		сая.төг	10,295.2	13,866.9	13,292.2	96%	(574.7)

1. Цахилгаан эрчим хүч:

Тайлант онд 155,364.8 мян.квт.ц ЦЭХ түгээсэн нь төлөвлөгөөнөөс 10,189 мян.квт.ц-аар илүү буюу 107.0% биелсэн ба урьд оноос 21,934.7 мян.квт.ц эрчим хүч илүү түгээсэн байна. Станц түүхэндээ 2018 онд хамгийн өндөр ЦЭХ-ний боловсруулалт 161.4 сая.кВт, түгээлт 140.1 сая.кВт хийгдэж байсан бол энэ онд 13.8 сая.кВт-аар илүү боловсруулалт, 15.3 сая.кВт-аар илүү түгээлт хийж хамгийн өндөр ЦЭХ-ний боловсруулалт, түгээлттэй жил болж байна.

ДХЦЭХ: Зорилтот түвшнээр батлагдсан ДХЦЭХ-ийн төлөвлөгөө 12.3 хувь буюу 20.4 сая.кВт.ц батлагдсан бөгөөд тоноглолын ачаалал авалт сайжирч түгээлт нэмэгдсэнтэй холбоотойгоор 11.3 хувь буюу 19.8 сая.кВт.ц гүйцэтгэлтэй гарсан байна. Батлагдсан төлөвлөгөөнөөс 0.576 сая.кВт.ц буюу 1.01 хувиар буурсан байна.

График 1: ЦЭХ түгээлт





График 2: ДХЦЭХ



2. Дулааны эрчим хүч:

Тайлант онд усаар 202,202 Гкал, уураар 58,603 Гкал, нийт 260,805 Гкал ДЭХ түгээсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 9,253 Гкал илүү түгээсэн байна. УБДС-ээс бага горим өгсөнтэй холбоотойгоор 04 болон 12 дугаар саруудад дулаан төлөвлөгөө тасарсан боловч жилийн дүнгээр 103.7 хувиар төлөвлөгөө биелэсэн байна.

График 3: ДЭХ-ний түгээлт




3. Нийт орлого:

Д/д	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он		Төл-өөс	
				төл	гүйц	Дүн	Хувь
1	ЦЭХ	22,574.30	30,485.20	33,414.70	34,753.9	1,254.66	104%
2	ДЭХ	3,471.00	3,653.30	3,661.60	3,050.12	-611.48	83%
3	ҮАБО	339.1	361	307.3	1,292.6	1,069.70	448%
Нийт		26,384.40	34,499.50	37,383.60	39,096.52	1,712.89	105%

Тайлангийн хугацаанд: Цахилгаан эрчим хүчний орлого 34,753.9 сая.төг, Дулааны эрчим хүчний орлого 3,050.1 сая.төг, Үйл ажиллагааны бус орлого 1,292.6 сая.төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарсан бөгөөд нийт орлогын дүн 39,096.5 сая.төг байна. Нийт борлуулалтын орлого төлөвлөгөөтэй харьцуулахад 1,712.9 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогын 89.3 хувийг ЦЭХ-ний, 10.7 хувийг ДЭХ-ний орлого эзэлж байна. 2024 онд үйл ажиллагааны бус орлогоор 307.3 сая төг олохоор төлөвлөн 1,292.6 сая төгрөг олж төлөвлөгөөг 985.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна

График 4: ҮА болон ҮАБ орлогын гүйцэтгэл

сая.төг




Үйл ажиллагааны бус орлогын задаргаа:

Д/д	Үзүүлэлт	Дүн /сая.төг/
1	Хүүгийн орлого	174.30
2	Торгуулийн орлого	46.84
3	Пүүгийн орлого	26.53
4	Үртэс шатаасны орлого /Монгол банк/	13.72
5	Түрээсийн орлого	40.41
6	Буц.конденсат	79.48
7	Бусад үйл ажиллагааны бус орлого	911.28
Нийт		1,292.55

4. Нийт зардал

Д/д	Үзүүлэлтүүд	2022 он гүйцэтгэл	2023 он гүйцэтгэл	2024 он		Төл-өөс	
				Төл	Гүйц	Төл	Гүйц
1	Үйл ажиллагааны зардал	28,104.80	34,321.60	39,374.80	38,628.10	-746.70	98%
2	Үйл ажиллагааны бус зардал	267.7	170.5	194	417.3	223.30	215%
Нийт зардал		28,372.50	34,492.20	39,568.80	39,044.40	-524.40	99%

График 5: Нийт зардлын гүйцэтгэл сая.төг



Зардлын задаргаа: мян.төг

№	Зардлын төрөл	2023 оны гүйцэтгэл	2024 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Түлшний зардал	14,072,027.5	14,873,200.0	14,736,962.7
2	Усны зардал	215,733.7	194,406.6	236,816.0
3	Цахилгааны зардал	199,088.4	206,922.1	172,018.6
4	Түүхий эд материалын зардал	112,536.9	175,013.3	154,829.6
5	Шатахууны зардал	225,204.4	306,305.9	233,215.1
6	Урсгал засвар	531,099.2	572,997.2	723,221.8
7	Үндсэн ба нэмэгдэл цалин	10,162,098.3	13,752,616.0	13,152,814.6
8	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	1,520,856.2	1,994,129.3	1,908,754.0
9	Албан томилолтын зардал	1,120.9	3,948.0	4,203.6
10	Конторын хангамжийн зардал	13,035.3	17,662.9	17,139.3
11	Харилцаа холбооны зардал	29,400.5	36,198.8	36,272.1
12	Харуул хамгаалалтын зардал	66,994.9	113,160.0	135,468.5
13	Хөдөлмөр хамгааллын зардал	297,510.9	394,099.8	404,056.5
14	Даатгалын зардал	3,114.3	3,474.4	3,105.8
15	Байгаль орчин хамгаалах зардал	21,343.6	38,923.0	31,343.9
16	Галын аюулаас хамгаалах зардал	24,538.5	31,600.0	54,835.8
17	Гүйцэтгэх удирдлагын зардал	172,589.7	198,766.1	179,761.7
18	ТУЗөвлөлийн зардал	120,081.4	122,280.6	141,424.6
19	Борлуулалт, маркетингийн зардал	-	8,710.0	-
20	Диспетчерийн зардал	21,331.9	21,587.7	22,220.7

21	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	95,953.7	82,507.0	125,300.0
22	Гадны үйлчилгээний хөлс	104,262.9	139,663.0	226,598.0
23	Сургалтын зардал	22,871.3	69,000.0	64,560.3
24	Бусад	3,442.9		
Үйл ажиллагааны зардал		28,605,231.1	33,357,171.9	32,764,923.3
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		3,857,522.7	4,489,140.0	4,338,350.1
33	Үл хөдлөх хөрөнгийн татвар	68,039.8	72,855.2	68,039.8
34	АТӨЯХ-ийн албан татвар	848.4	1,200.0	858.2
35	Газрын төлбөр	23,823.6	92,386.3	34,491.2
36	Усны нөөц ашигласны төлбөр	187,836.8	292,034.1	181,072.9
37	Бусад татвар хураамж	42,363.6	66,140.8	39,506.5
ААНОАТ-аас бусад татварын зардал		322,912.3	524,616.4	323,968.5
Бүрэн өөрийн өртөг		32,785,666.0	38,370,928.3	37,427,241.9
35	Хүүгийн зардал-Урт хугацаат зээлийн	9,940.2	9,102.5	9,102.5
36	Хүүгийн зардал-Богино хугацаат зээлийн			
37	Ажиллагсдын нийгмийн зардал	1,522,694.2	994,809.2	1,121,292.9
Өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн		1,532,634.4	1,003,911.7	1,130,395.5
38	Валютын ханшны алдагдал		-	
39	Үйл ажиллагааны бус зардал	170,505.3	194,000.0	417,927.9
Үйл ажиллагааны бусад зардлын дүн		170,505.3	194,000.0	417,927.9
НИЙТ ЗАРДАЛ /42+45+48/		34,488,805.8	39,568,840.0	38,975,565.2

а. Цалингийн зардал:

сая.төг					
№	Цалингийн төрөл	2023 он	2024 он	Өөрчлөлтийн дүн	Өөрчлөлтийн хувь
1	Бодогдсон цалин	4091.54	5368.28	1329	32.48%
2	Илүү цагийн нэмэгдэл	595.98	680.94	182.36	14.25%
3	Шөнийн нэмэгдэл	348.26	530.62	84.96	25.36%
4	Удаан жилийн нэмэгдэл	1074.72	1417.39	342.66	31.88%
5	Сарын үр дүнгийн нэмэгдэл	1873.95	2483.41	609.46	32.52%
6	ЭХТА	14.52	13.11	-1.42	-9.7%
7	Ажил хавсарсны нэмэгдэл	55.65	48.33	-7.32	-13.14%
8	Зөвлөхийн нэмэгдэл	20.14	18.05	-2.1	-10.42%
9	Мэргэшсэний нэмэгдэл	27.39	33.41	6.02	21.97%
10	Нүүрс буулгагчийн нэмэгдэл	39.43	70.10	30.67	77.7%
11	Амралтын мөнгө	965.7	1027.82	62.1	6.4%
12	Актны мөнгө байгууллагаас	46.56	38.76	-7.69	-16.55%
13	Бусад нэмэгдэл	129.12	537.70	408.58	316%
14	Олговорт цалин		13.33	13.33	-
15	ЖҮДШ	1068.56	958.71	-109.85	-10.2%
НИЙТ		10,351.46	13,292.23		

Гүйцэтгэх захирлын 2024 оны 02 сарын 08-ны өдрийн А/17 тоот тушаал, 2024 оны 08 сарын 15-ны өдрийн А/88 тоот тушаалаар хөдөлмөрийн дотоод журам болон хамтын гэрээний дагуу цалинг 2 удаа нэмэгдүүлсэн.

- Өмнөх онд шөнийн цаг 88703 цаг байсан бол 2024 онд 88,169 цаг болж 534 цагаар, илүү цаг 36823-аас 26460 болж 10,363 цагаар тус тус буурсан.
- Сарын үр дүнгийн дундаж хувь хэмжээ 2023 онд 47.76% байсан бол 2024 онд 47.31% болж 0,45%-иар буурсан.
- Эрчим хүчний тэргүүний ажилтан 2023 онд 70 хүн байсан бол 2024 онд 69 хүнд нэмэгдэл олгсон.
- Мэргэшсэний нэмэгдэл 13 хүн авдаг байсан бол 2024 онд 11 хүн авч байгаа.
- Хөдөлмөрийн чадвараа түр алдасны тэтгэмж 86 хүн 101.3 сая.төг авсан бол 2024 онд 58 хүнд 81.02 сая.төг-ийн тэтгэмж нийгмийн даатгал болон байгууллагаас олгосон.
- Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл өмнөх онд 260 хүнд 1,068.6 сая.төг олгож байсан бол тайлант онд 251 хүнд 958.7 сая.төгрөгийн нэмэгдэл олгосон.


Нийгмийн даатгалын байгууллагатай холбоотой:

Нийгмийн даатгалын тухай хууль нь 2023 оны 07 сарын 07-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон өөрчлөгдөж эрүүл мэнд, тэтгэвэр, тэтгэмжийн хуулиуд багц болон шинэчлэгдэн 2024 оны 01 сарын 01-нээс мөрдөж эхлэх болсонтой холбогдуулан ажилчдын ажил мэргэжил албан ёсны кодчилсон системд орсноор ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд тодорхой өөрчлөлт орсон. Энэ нь үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмжийн хувь хэмжээ ангиллын дагуу 0.5-2.5-н хооронд ажил мэргэжлийн хэвийн, хэвийн бус, хүнд, халуун, хортой гэх мэт нөхцөлүүдээс хамаарч өөрчлөгдсөн.

Уг өөрчлөлтийн хүрээнд нийт ажилчин албан хаагчдыг коджуулан Нийгмийн даатгалын шинэ системд бүртгэх, шилжилт хөдөлгөөн хийх зэргийг тухай бүрт хийж дараа сарын 5-ны дотор тайланг илгээн баталгаажуулж 2024 онд нийгмийн даатгалын шимтгэлд нийт 3,495.0 сая.төг тайлагнан тушааж өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.


5. Ашиг, алдагдал

Д/д	Үзүүлэлт	2023 он гүйц	2024 он		Өмнөх оноос		Төлөвлөгөө-с	
			Төл	Гүйц	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Нийт орлого	34,499.5	37,383.6	39,096.53	4,597.03	113%	1,712.93	105%
2	Нийт зардал	34,492.2	39,568.8	38,975.57	4,483.37	113%	-593.23	99%
3	Ашиг алдагдал	10.71	(2,185.2)	120.96	110.25	10.3	2,306.16	20.9
4	Цэвэр ашиг	7.40	(2,185.2)	106.11	98.71	14.3	2,291.31	21.6



6. Авлага:


Хугацаа	Дүн /сая.төг/
2021 он	3,922.50
2022 он	1,685.00
2023 он	1,280.30
2024 он төлөвлөгөө	1,365.00
2024 он гүйцэтгэл	1,651.90



ЭХС-ийн баталсан 2024 оны зорилтот түвшинд нийт авлага 1,365.0 сая.төг төлөвлөгдсөн бөгөөд гүйцэтгэлээр 1,651.9 сая.төг гарч 286.9 сая.төг өссөн байна. “ДҮТ” ТӨХХК 1,246.0 сая төгрөг.

7. Өглөг:

Хугацаа	Дүн /сая.төг/
2021 он	3,075.60
2022 он	1,308.20
2023 он	1,839.10
2024 он төлөвлөгөө	1,263.70
2024 он гүйцэтгэл	1,276.40




БХӨТ: Оны эхний үлдэгдэл 1,483.5 сая төгрөг, тухайн жилд 962.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 520.9 сая төгрөгөөр буурсан байна.


8. Жишмэл түлшний хувийн зарцуулалт:

Жишмэл түлшний хувийн зарцуулалт 2024 онд ЦЭХ-нд 549.42 гр/кВт.ц гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 46.8 гр/кВт.ц-аар, төлөвлөсөн хэмжээнээс 65.8 гр/кВт.ц-аар тус тус хэмнэж, дулаанд 193.47 кг/Гкал гарсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 3.9 кг/Гкал-аар, төлөвлөгөөнөөс 7.1 кг/Гкал-аар тус тус буурч нийлбэр дүнгээр 3,958.7 тн жишмэл түлш хэмнэсэн буюу бодит нүүрсээр 12,292 тн хэмнэсэн.

ЦЭХ:



ДЭХ:



“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК